

## МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### 1. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэснийг хэрэгжүүлэх хууль зүйн баталгааг бүрдүүлэх;

2/ “Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-т Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг Үндсэн хуулийн агуулга, үзэл санаанд нийцүүлэн хуульчлан бататгах арга хэмжээ авахаар заасныг хэрэгжүүлэх;

3/ “Үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал”-д төрийн мэдээллийг нээлттэй болгох, иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавихаар заасныг хэрэгжүүлэх;

4/ Монгол Улсын Засгийн газрын “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийн “Зохистой засаглал” бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах талаар арга хэмжээ авахаар заасныг хэрэгжүүлэх;

5/ Хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад ямар ч асуудлаар олон нийтэд өгөх мэдээлэл нээлттэй, үнэн зөв байх нөхцөл боломжийг бүрдүүлэх зэрэг үндэслэл, шаардлагыг харгалзан хуулийн төслийг боловсруулна.

Хуулийн төслийг боловсруулахдаа Лондон хотод байрлах “XIX зүйл” хэмээх төрийн бус байгууллагаас 2001 онд гаргасан Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн загварын үзэл санааг ирддлага болгоно.

### 2. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг дор дурьдсан бүлэгтэйгээр боловсруулахаар төлөвлөж байна. Үүнд:

**Нэг.** Нийтлэг үндэслэл

**Хоёр.** Төрийн байгууллага, албан тушаалтан, иргэний эрх, үүрэг

**Гурав.** Мэдээллийн комиссар

**Дөрөв.** Иргэдээс байгууллага, албан тушаалтанд

асуулга тавих, асуулгад тавих шаардлага

**Тав.** Асуулгыг хүлээн авах, хянан үзэх, хариу өгөх

**Зургаа.** Бусад зүйл

Хуулийн төслийн зохицуулах зүйл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж асуулга тавих, түүнийг байгууллага, албан тушаалтнаас хянан үзэж хариу өгөхтэй холбогдсон харилцаа байхаар төлөвлөж байна.

Хуулийн үйлчлэх хүрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн, байгууллагын, хувь хүний нууцад хамааруулсан мэдээлэлд хамаарахгүй.

Хуулийн төсөлд хэрэглэх “асуулга”, “иргэн”, “төрийн байгууллага”, “албан тушаалтан”, “мэдээлэл” зэрэг зарим нэр томъёоны ойлголтыг өгнө.

Мэдээллийг Монгол Улсын иргэд авч байх эрхтэй байх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний адил төрийн байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах эрхтэй байх юм.

Төсөлд төрөөс мэдээллийн эрх чөлөөг хангах талаар баримтлах үндсэн зарчмуудыг тогтоож өгнө.

Энэхүү хуулийн төслөөр асуулга тавигч иргэн нь төрийн байгууллагаас мэдээлэл авах хэлбэрээ өөрөө чөлөөтэй сонгох, мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх, мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтны талаар гомдол гаргах эрхтэй байх. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах, асуулгад хуулиар тогтоосон хугацаанд нь хариу өгөх, энэхүү хуулийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх зэрэг үүрэгтэй байхаар тус тус тусгана.

Иргэд мэдээлэлтэй холбоотой баримттай танилцах, холбогдох баримт бичгийн хуулбар авах, лавлагаа авах, мэдээлэл нийтлэгдсэн албан ёсны эх сурвалжийн талаар мэдээлэл авах зэрэг мэдээлэл авах тодорхой хэлбэрүүдийг хуулийн төсөлд тусгана.

Иргэд төрийн байгууллагаас мэдээлэл авсныхаа төлөө үйлчилгээний хураамж төлж байх бөгөөд үйлчилгээний хураамжийн хэмжээ, түүнийг хөнгөлөх, чөлөөлөх, зарцуулах журмыг Засгийн газар тогтоох нь зүйтэй гэж үзэв.

Хуулийн төсөлд төрийн байгууллага, албан тушаалтанд асуулга тавих хэлбэр, асуулгад тавих шаардлага, асуулгыг хүлээн авах, хянан үзэх, хариу өгөх журмыг нарийвчлан тодорхойлохоор төлөвлөж байна.

Эрх, хууль ёсны ашиг сонирхолыг нь зөрчсөн гэж үзвэл иргэд тухайн байгууллага, албан тушаалтны шууд харьяалах дээд шатны байгууллагад гомдол гаргах. Хэрэв дээд шатны байгууллагын шийдвэрийг зөвшөөрөөгүй бол шүүхэд гомдол гаргах эрхтэй байхаар төсөлд тусгана.

Иргэдийн тавьсан асуулгыг хүлээн аваагүй, тэдэнд үнэн зөв мэдээлэл өгөөгүй буруутай албан тушаалтанд эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжийн дагуу сахилгын хариуцлага, хугацаанд нь хариу өгөөгүй буруутай албан тушаалтанд шүүгч торгох захиргааны шийтгэлийг тус тус хүлээлгэнэ.

### **3. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл батлагдсаны дараа дор дурьдсан нийгэм, эдийн засгийн үр дагавар гарна гэж тооцож байна.

1/ Төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтийн өмнө нээлттэй болно.

2/ Иргэдийн үнэн зөв мэдээлэл олж авах боломж нэмэгдэж, иргэд мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх механизмын эрх зүйн үндэс бүрдэнэ.

3/ Мэдээлэл нээлттэй болсноор иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдэж, төрийн үйл ажиллагаанд тавих хяналт сайжирна.

Хуулийн төсөл батлагдсаны дараа төрийн байгууллагууд түүнд заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай уялдан тэдгээрийн бүтцэд дээрхи үүргийг тусгайлан хариуцсан ажилтны орон тоо бий болох, эсхүл аль нэг ажилтнаар хавсруулан гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

### **4. Төсөл нь Монгол Улсын бусад хуультай хэрхэн уялдах, цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй нийцүүлж Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиуд дахь үндэслэлгүй хязгаарлалтуудыг хасах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна.